



# ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 1025

Мандалговь

## Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Дэлгэрхангай сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 20,000,000 /хорин сая/ төгрөгийн балансын үнэтэй, 17,000,000 /арван долоон сая/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй ДУА 00-79 улсын дугаартай TOYOTA Land Cruiser 100 маркийн автомашиныг Дэлгэрхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр: Дэлгэрхангай сумын Засаг даргын тамгын газрын дарга /Ё.Сайхантуяа/, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Ц.Сансармаа/ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


- 2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг сум болон байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.



ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын  
24- ний өдрийн 125 дугаар тогтоолын хавсралт



Дэлгэрхангай сумын ЗДТГ-ын балансаас балансад шилжүүлэх  
тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэр лэсэн он	Ашиглалтанд орсон он	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сер и	Дугаар			Арлын дугаар	моторын дугаар	моторын эзлэхүүн				
1	Суудал	Toyota	Сер и	Дугаар	2004	1/2/2014	Арлын дугаар	УЗЖ10001 50628	4660В	357745	20,000,000	2,999,999.97	17,000,000.03
<b>Хөрөнгийн дүн</b>											<b>20,000,000/</b>	<b>Хорин сая</b>	<b>төгрөг/</b>